

## Банкны салбарын эргэн тойронд

10.12 – Хаан банк болон БНХАУ-ын Тариалангийн банк “Төгрөг, юанийн хамтын ажиллагааг өргөжүүлэх харилцан ойлгомцлын санамж бичиг”-т гарын үсэг зурлаа. [khanbank.com](http://khanbank.com)

10.25 – ТиДиБи Онлайн үйлчилгээний нууцлалыг сайжруулах зорилгоор “Төхөөрөмж баталгаажуулалт”-ын үйлчилгээг нэвтрүүллээ. [tdbm.mn](http://tdbm.mn)

11.03 – Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн мэдүүллээ. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

11.08 – ХасБанк Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Зээлийн батлан даалтын тогтолцоог дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх нь” төслийн дамжуулан зээлдүүлэгч банкаар шалгарч “Зээлийн батлан даалтын сан”-тай хамтарч ажиллахаар боллоо. [xacbank.mn](http://xacbank.mn)

11.09 – Аж ахуй нэгж байгууллагууд дулааны төлбөрөө гялсбанкаар дамжуулан төлөх боломжтой. [statebank.mn](http://statebank.mn)

11.13 – Үндэсний төлбөрийн системийн тухай хууль 2018 оны 1-р сарын 1-ээс хэрэгжиж эхлэхтэй холбогдон Монголбанк “Төлбөрийн картын журам”-ын шинэчлэн боловсруулсан төслийг танилцууллаа.. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

11.13 – Монголын банкны холбооноос УИХ-ын нэр бүхий гишүүд хуулиар болон Монголбанкны шийдвэрээр зээлийн хүүнд дээд хязгаар тогтоох агуулга бүхий хуулийн төслүүд УИХ-д өргөн мэдүүлж эхэлсэнтэй холбогдуулан мэдэгдэл гаргав. [mba.mn](http://mba.mn)

11.13 – Уур амьсгалын ногоон сан Хасбанкны өргөн барьсан сэргээгдэх эрчим хүчний төслийг санхүүжүүлэхээр боллоо. [xacbank.mn](http://xacbank.mn)

11.15 – ХасБанк, МИАТ ТӨХК-тэй хамтран МИАТ кредит картыг зах зээлд нэвтрүүллээ. [xacbank.mn](http://xacbank.mn)

11.17 – Улаанбаатар хотын банк QPAY үйлчилгээг зах зээлд нэвтрүүллээ. [ubcbank.mn](http://ubcbank.mn)

11.23 – Fitch Ratings агентлаг ХасБанкны зээлжих зэрэглэлийн төлөвийг “Эерэг” болгож сайжрууллаа. [xacbank.mn](http://xacbank.mn)

11.23 – “Жижиг дунд бизнес (ЖДБ)-ийн санхүүгийн хүртээмж форум 2017” арга хэмжээ “Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх хамтын ажиллагаа” сэдэв дор зохион байгуулагдлаа. [mba.mn](http://mba.mn)

11.24 – Монголбанк банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12-р сарын 31-с өдрөөс 100,0 тэрбум төгрөг болгох шийдвэр гаргалаа. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

12.01 – Үндэсний хөрөнгө оруулалтын банк ЕВРО-гийн гуйвуулга илгээх банкны шимтгэлээ 0₮ боллоо. [nibank.mn](http://nibank.mn)

12.07 – ХХБ цаасны хэрэглээг багасгах зорилгоор бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ брошурыг цахим хэлбэрээр гаргалаа. [tdbm.mn](http://tdbm.mn)





12.19 – Монголын банкны холбоо болон Монголын даатгагчдын холбоо хамтарч ажиллана. [mba.mn](http://mba.mn)

12.19 – Монголын банкны холбооны ээлжит 12 дахь удаагийн чуулган зохион байгуулагдаж 2017 оны ажлаа дүгнэлээ. [mba.mn](http://mba.mn)

12.25 – Монголбанкны мөнгөний бодлогын зөвлөл хуралдаж, бодлогын хүүг 1,0 нэгж хувиар бууруулж 11% болгох шийдвэр гаргалаа. [mongolbank.mn](http://mongolbank.mn)

12.27 – ХХБ “Үнэт цаасны өмчлөх эрхийн тухайлсан бүртгэл хөтлөх тусгай зөвшөөрөл”-ийг авсан анхны Кастодиан банк боллоо. [tdbm.mn](http://tdbm.mn)

## Банкны салбарын гол үзүүлэлтүүд<sup>1</sup>



### Нийт актив = 28,8 их наяд төгрөг

Банкны салбарын нийт актив 2017 оны 4-р улиралд 28,8 их наяд төгрөг болж өмнөх улирлаас 0,7 их наяд төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 3,5 их наяд төгрөгөөр өслөө.

### Ашиг = 249,1 тэрбум төгрөг

Банкуудын өөрийн хөрөнгө 2017 оны 4-р улирлын байдлаар 3,15 их наяд төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7,2% өслөө. Харин банкны салбарын ашиг оны 4-р улирлын байдлаар 249,1 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийн ашгаас 72,6 тэрбум төгрөгөөр илүү байна.

### Банкны нөөц = 3,38 их наяд төгрөг

Банкны нөөц 2017 оны 4-р улирлын байдлаар 3386 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 251 тэрбум төгрөг буюу 15,7 орчим хувиар өсжээ. Харин төв банкны нөөц өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 6 дахин өсөж 3445 тэрбум төгрөг боллоо.

### Чанаргүй зээл 8,9%

Нийт дотоодын зээл тогтмол өссөөр 2017 оны 4-р улирлын байдлаар 12,9 их наяд төгрөгт хүрээд байна. Харин чанаргүй зээлийн хэмжээ өндөр түвшинд хэвээр байна. 2017 оны 4-р улирлын байдлаар нийт чанаргүй зээл 1,15 их наяд төгрөг буюу нийт зээлийн 8,9%-ийг эзэлж байна.

<sup>1</sup> Эх сурвалж: Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд, Монголбанк


# БАНКУУДЫН ӨРСӨЛДӨӨНИЙ ТОЙМ

2017 он – IV улирал




## Ипотекийн зээл = 4,25 их наяд төгрөг

Нийт ипотекийн зээл 4,25 их наяд төгрөг хүрсэн бол үүнээс орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх хөтөлбөр (ОСИСТБ)-н дагуу 3,29 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Ипотекийн зээлийн хэмжээ тус хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнээс хойш тогтмол өссөөр байна.




1\$=2433₮ 1¥=369₮

Монголбанкнаас зарласан ханшийн сарын дундаж хөдөлгөөнөөр 2017 оны 12-р сарын дундаж Ам.доллар-ын ханш 2433₮, Юань-ийн ханш 369₮ байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Ам.долларын ханш 49₮-р буурсан, Юанийн ханш 11₮-р өссөн үзүүлэлт юм.



## Харилцах+Хадгаламж=13,5 их наяд ₮

2017 оны 4-р улирлын байдлаар банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 9,6 их наяд төгрөг, харилцах 3,9 их наяд төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж 19,5%-иар, харилцах 34,4%-иар өссөн байна.



## Пассив = 25,6 их наяд төгрөг

2017 оны 4-р улирлын байдлаар банкны салбарын нийт пассив 25,6 их наяд төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,4%-иар өссөн байна.



## Онцлох: Банкуудын иргэд болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуй нэгжүүдэд олгосон зээл<sup>2</sup>

Энэ удаагийн тоймоор банкуудын иргэд болон аж ахуй нэгжүүдэд олгосон зээлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг оруулж байна. 2017 он 12-р сарын байдлаар арилжааны банкууд 1 сая гаруй иргэдэд 6,4 их наяд төгрөгийн зээлийг дундажаар 19,4%-ийн хүүтэй олгосон байна. Хүснэгт 1-с та зээлийн залааргааг харж болно. Иргэдийн зээлийн залааргааг

харвал цалингийн зээл дийлэнх хувийг буюу 33%-ийг эзэлж байна. Хэрэглээ, цалин, тэтгэврийн зээлтэй 750,000 гаруй иргэн байгаа бол жижиг дунд үйлдвэрлэлийн зээл авсан ердөө 40,467 иргэн байна. Ипотек болон тэтгэврийн зээлийн хүүний хувьд төрөөс хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг тул харьцангуй бага байна.

Хүснэгт 1. Банкуудаас иргэдэд олгосон төгрөгийн зээл

	Зээлийн хэмжээ /тэрбум төгрөг/	Зээлдэгчдийн тоо	Жигнэсэн дундаж хүү
Иргэдийн нийт зээл	6 439	1 003 311	19,4%
Ипотекийн зээл	1 683	36 265	10,5%
Жижиг дунд үйлдвэрлэлийн зээл	758	40 467	22,8%
Хэрэглээний зээл	651	241 261	22,9%
Цалингийн зээл	2 131	286 222	22,4%
Тэтгэврийн зээл	695	224 802	16,8%
Бусад	520	174 294	16,8%

Харин Жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгч аж ахуй нэгжүүдийн (ААН) хувьд арилжааны банкуудаас 5268 ААН нийт 1,45 их наяд тэрбум төгрөгийн зээлийг 19,3%-ийн дундаж хүүтэй авсан байна. Салбараар нь аваад үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн их зээл олгогдсон байна. Мөн хөдөө аж ахуй, ан агнуурын салбарт

хамгийн бага хүүтэй буюу 16,2%-ийн дундаж хүүтэй зээл олгогддог байна. Харин хамгийн их зээл олгогдсон, зээлийн эрэлт ихтэй боловсруулах үйлдвэрлэлийн салбарт хамгийн өндөр хүүтэй буюу 22,2%-ийн дундаж хүүтэй зээл олгогдсон байна.

Хүснэгт 2. Банкуудаас ЖДҮ эрхлэгч ААН-үүдэд олгосон төгрөгийн зээл

	Зээлийн хэмжээ /тэрбум төгрөг/	Зээлдэгчдийн тоо	Жигнэсэн дундаж хүү
ЖДҮ эрхлэгч ААН-д олгосон зээл	1 455	5268	19,3%
ХАА, ан агнуур	121	447	16,2%
Боловсруулах үйлдвэрлэл	453	1 169	22,2%
Барилга	224	414	20,2%
Бөөний болон жижиглэн худалдаа	249	1 125	17,6%
Үйлчилгээ	107	693	20,2%
Бусад	301	1 420	18,3%

<sup>2</sup> Эх сурвалж: Монголбанкнаас гаргасан банкуудын иргэд болон ЖДҮ эрхлэгч аж ахуй нэгжүүдэд олгосон зээлийн тайлан

## Банкуудын өрсөлдөөн

Арилжааны банкны үндсэн үүрэг нь мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй байгаа хэсгээс хөрөнгийг татаж, дутагдалтай байгаа хэсэгт шилжүүлэн, харилцагчдын итгэл дээр суурилсан санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа үзүүлэх, харилцагчдын хоорондын төлбөр тооцоог хийж гүйцэтгэх бөгөөд эцсийн зорилго нь санхүүгийн үйлчилгээгээр дамжуулан ашиг олох явдал билээ.

2017 оны 4-р улирлын байдлаар банкны салбарт нийт 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкуудад Хаан банк, ХХБ, Голомт банк, Хасбанк, Төрийн банк, Улаанбаатар хотын банк гэсэн 6 банк багтаж байна. Эдгээр банкууд нь системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

Арилжааны банкуудын санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, өөрчлөлт хөдөлгөөнийг харуулдаг мэдээллийн гол эх сурвалж бол банкуудын санхүүгийн тайлан юм. Банкуудын өрсөлдөөний тоймыг гаргахдаа санхүүгийн хураангуй тайланг ашиглан дараах үзүүлэлтүүдийг харьцуулсан болно. Үүнд:

- Актив
- Зээл
- Харилцах, хадгаламж
- Ашиг

Эдгээр үзүүлэлтээр арилжааны банкуудыг харьцуулахдаа активын хэмжээгээр нь Том-3 банк, Дунд-3 банк, бусад банкууд гэж ангилсан

Энэ удаагийн тайланд Капитал банкны мэдээлэл ороогүй болно. Мөн дараах банкуудын өрсөлдөөний тоймыг Капитал банкнаас бусад 13 банкны улирлын санхүүгийн тайланг ашиглаж тооцсон учир Монголбанкнаас гаргадаг нийт банкны салбарын үзүүлэлтээс ялгаатай гэдгийг анхаарна уу.



### АКТИВ

### БАНКУУД

#### ТОМ-3 БАНК

>3 их наяд төгрөг

Худалдаа хөгжлийн банк  
Хаан банк  
Голомт банк

#### ДУНД-3 БАНК

1-3 их наяд төгрөг

Хасбанк  
Төрийн банк  
Улаанбаатар хотын банк

#### БУСАД БАНКУУД

<1 их наяд төгрөг


Капитал банк  
Чингис хаан банк  
Капитрон банк  
Үндэсний хөрөнгө оруулалтын банк  
Ариг банк  
Богд банк  
Кредит банк  
Тээвэр хөгжлийн банк

## АКТИВ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт актив 28 их наяд төгрөг байна. Том-3 банк нийт активын 69,2%, Дунд-3 банк 24,4%, жижиг банкууд 6,4%-ийг эзэлж байна.

1 жилийн өмнөх мөн үетэй харьцуулахад Том-3 банкны актив 9,1%, Дунд-3 банкны актив 20,6%, жижиг банкуудын актив 56,2% тус бүр өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, активаар, 4У'17



Банкуудын активын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлтийн хувь




## ЗЭЭЛ




Тайлант хугацаанд тайланд орсон 13 банкны нийт зээл 12,7 их наяд төгрөг байна. Үүнээс 67,2%-г Том-3 банк, 26,4%-г Дунд-3 банк 6,4%-г жижиг банкууд бүрдүүлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 5,8%-иар, Дунд-3 банк 17,6%-иар, жижиг банкууд 46,8%-иар тус тус зээлийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Харин нийт дүнгээр авч үзвэл банкуудын зээлийн хэмжээ 10,7% өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 4У'17



## Зээлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр






## ХАДГАЛАМЖ БА ХАРИЛЦАХ




Тайлант хугацаанд тайланд орсон нийт 13 банкны харилцах ба хадгаламжийн хэмжээ 15,3 их наяд төгрөг байна. Үүнээс 70,5%-г Том-3 банк, 23,1%-г Дунд-3 банк, 6,4%-г жижиг банкууд эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 22%-иар, Дунд-3 банк 18%-иар, жижиг банкууд 65%-иар тус бүр харилцах ба хадгаламжийн хэмжээгээ нэмэгдүүлжээ. Нийт дүнгээр нь авч үзвэл 22,8%-иар өсчээ.

Зах зээлд эзлэх хувь, 4У'17



## Хадгаламж ба харилцахын хэмжээ, тэрбум төгрөгөөр болон өсөлт








## АШИГ

2017 оны 4-р улирлын байдлаар тайланд орсон 13 арилжааны банкуудын санхүүгийн тайлангийн нийлбэр дүнгээр банкууд нийт 269,7 тэрбум төгрөгийн ашигтай (татварын дараах дүн) ажиллажээ. Тайланд орсон 13 банкны хувьд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45,3 тэрбум төгрөгөөр илүү ашигтай ажилласан байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад Том-3 банк 22%-иар, Дунд-3 банк 28%-иар тус бүр ашгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн бол жижиг банкуудын ашиг 17% буурсан нь ҮХОБ болон Чингис Хаан банкуудын алдагдалаас үүдэлтэй.

Банкуудын ашиг, алдагдал:



Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень 4У'17, Монголбанк
2. Ипотекийн зээлийн тайлан 4У'17, Монголбанк
3. Банкуудын нэгдсэн балансын гол үзүүлэлтүүд 4У'17, Монголбанк
4. Монголбанкны ханшийн сарын дундаж хөдөлгөөн, Монголбанк
5. Арилжааны банкуудын улирлын санхүүгийн тайлан 4У'17